

01 тоот, 10 давхар, 5-р хороолол /14252/
Сөүлийн гудамж 13А “Алтан Жолоо Тауэр”
оффис, 3-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот,

Утас: +976 - 77070101

Цахим шуудан: Service@lend.mn

2026 оны 04 сарын 15 өдөр

№ 04/1036

Улаанбаатар хот

**Ногдол ашгийн тайлан
хүргүүлэх тухай**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/03 тоот тогтоолоор компанийн 2025 оны нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 16.5 /арван зургаан төгрөг тавин мөнгө/-н ногдол ашиг хуваарилж 2026 оны 04 сарын 03-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн болно.

Компани ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан 2025 оны 04 сарын 03-ны өдөр ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан ба үүнтэй холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 28 дугаартай “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу “Ногдол ашиг хуваарилалтын тайлан”-г хүргүүлж байна.

Хавсралтаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 26/03 тогтоол болон ҮЦТХТ-өөр дамжуулан ногдол ашиг тараасан талаарх мэдэгдлийг хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.УУГАНБАЯР

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН-2025

Ногдол ашиг олгосон хуулийн этгээд: “ЛэндМН ББСБ” ХК

Ногдол ашиг олгох шийдвэрийн огноо: 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн дүн: 16.5 /Арван зургаан төгрөг тавин мөнгө/

Бүртгэлийн өдөр: 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Ногдол ашиг олгох огноо: 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

Ногдол ашиг хуваарилах шийдвэрийн тухай:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26/03 тоот тогтоолоор компанийн 2025 оны нийт цэвэр ашгийн 30.4 хувийг буюу нэгж хувьцаанд 16.5 /арван зургаан төгрөг тавин мөнгө/ нийт 12,198,477,769.5 /Арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран есөн төгрөг тавин мөнгө/ төгрөгийг ҮЦТХТ ХХК-иар дамжуулан 2026 оны 04 сарын 03-ны өдрийн дотор нийт хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц:

“ЛэндМН ББСБ” ХК” нь нийт 800,000,000 ширхэг хувьцаатай ба үүнээс 60,698,317 ширхэг халаасны хувьцаа, үлдэх 739,301,683 ширхэг саналын эрхтэй хувьцаатай болно.

Бүртгэлийн өдрөөрх “ҮЦТХТ” ХХК-иас ирүүлсэн нийт хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээгээр “ЛэндМН ББСБ” ХК” саналын эрхтэй хувьцааг нийт 13,256 /Давхардсан тоогоор/ ширхэг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Үүнээс хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдлаар тодорхойлогдоно.

	Хувьцаа	Хувьцааны тоо	Үнэт цаасны дансны тоо
1	5 хувиас дээш	600,000,000	1
2	Бусад хувьцаа эзэмшигчид	139,301,683	13,255

Ногдол ашиг хуваариалан байршуулсан тухай:

Компани нь холбоо хамаарал бүхий 2 хувьцаа эзэмшигчдийн нийт 9,730,418,016 төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг хуваарь тохирон олгохоор тохиролцсон ба бусад хувьцаа эзэмшигчдэд олгох нийт 1,847,944,050.20 төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд 2026 оны 04 сарын 03-ны өдөр байршуулсан болно.

	Хувьцаа эзэмшигчдийн	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьцааны тоо	Олгосон ногдол ашиг
1	Гадаадын иргэн	38	15,223,774	238,708,776.32
2	Гадаадын ААН	3	5,900,091	77,881,201.20
3	Дотоодын иргэн	13,189	60,614,238	950,567,458.76
4	Дотоодын ААН	24	36,803,260	580,786,613.92
	Нийт	13,254.00	118,541,363.00	1,847,944,050.20

Тайлан гаргасан:



/Д.Шүрэнцэцэг/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр


№ 26/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “**Компани**”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**”)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 16.5 (арван зургаа аравны тав) төгрөгөөр тогтоож, 2025 оны цэвэр ашгийн 30.4 (гуч аравны дөрөв) хувийг буюу 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны тав) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд байршуулж, Хувьцаа эзэмшигчдийн дансанд дамжуулан олгохоор шийдвэрлэсүгэй.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.





**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Самбуугийн гудамж 16/1
Утас: 70120460
И-мэйл: info@mcsd.mn Вэб хуудас: www.mcsd.mn

2026.04.03 № 01/342
танай _____-ны № _____-т

"ЛЭНДМН ББСБ" ХК-Д

Танай байгууллагатай 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан 03/05 тоот ногдол ашиг зуучлуулан тараах гэрээний дагуу нийт 13,254 хувьцаа эзэмшигчдийн дансанд 118,541,363 ширхэг хувьцаанд ногдох 1,847,944,050.20 / нэг тэрбум найман зуун дөчин долоон сая есөн зуун дөчин дөрвөн мянга тавин төгрөг 20 мөнгө/-ийг 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр байршуулсан болно.

Хувийг: Санхүүгийн Зохицуулах Хороонд

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ЭНХСАЙХАН

